

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2022 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнав)

2022-06-28

Улаанбаатар хот

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага Хэрэгжүүлэх хугацаа	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг), эх үүсвэр	Суурь түвшин	2022 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц, үр дүн, хэрэгжилтийн хувь
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	
1	2	3	4	5	6	7	8	9
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.								
3.2.7. Хүнд үйлдвэрлэл-ийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	УУХУЯ, "ЭУ" ТӨҮГ, ТӨБЗГ 2020-2024	1,628,400.0 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт (30% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 70% гадаад/дотоод хөрөнгө	0%	Үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлж, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийнэ. 50%	690,754.0	13,811.0	ТӨБЗГ - ТӨҮЗХ Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2020 онд боловсруулсан. Гэрээний нийт дүн 3,696.0 сая төгрөг. Зэсийн баяжмалыг хайлуулах, боловсруулах явцад гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг боловсруулж, элементийн хүхэр үйлдвэрлэх туршилт, судалгааны ажлыг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан гэрээний үндсэн дээр энэхүү технологийн патентыг эзэмшигч БНХАУ-ын ENFI компанитай хамтран гүйцэтгэж байна. Элементийн хүхэр үйлдвэрлэх Үйлдвэрлэлийн туршилтын ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байна. Туршилтын ажлын санхүүжилтийн гэрээний дүн 11,245.0 сая

			<p>оруулалт, зээл)</p>						<p>төгрөгөөс 90% буюу 10,115.0 сая төгрөг шилжүүлсэн.</p> <p>China ENFI компани туршилтын үйлдвэр барьж байгуулах бүх шаардлагатай зөвшөөрлийг орон нутгаас авсан, барилга угсралт, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн захиалга эхэлсэн. Туршилтын үйлдвэрийг 2022 оны 8 дугаар сарын 01-ний дотор барьж дуусган, үйлдвэрлэлийн туршилтыг 2022 оны 11 дүгээр сарын 1-нд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын түшиглэн байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл"-д шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр УУХҮЯ-ны ЭБМЗөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэгдэн, дэмжигдсэн.</p> <p>Хэрэгжилт: 30.0 хувь</p> <p>Тэмдэглэл: Зэсийн баяжмалыг хайлуулах, боловсруулах явцад гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг боловсруулж, элементийн хүхэр үйлдвэрлэх туршилт, судалгааны ажил хийгдэж байгаа. Туршилтын ажлын санхүүжилтийн 90% буюу 10,115.0 сая төгрөг шилжүүлсэн. China ENFI компани туршилтын үйлдвэр барьж байгуулах бүх шаардлагатай зөвшөөрлийг орон нутгаас авсан, барилга угсралт, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн захиалга эхэлсэн.</p>
<p>6."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах</p>	<p>УУХҮЯ, "ЭҮ" ТӨҮГ, ТӨБЗГ</p>	<p>167,371.0 Гадаад, дотоодын хөрөнгө</p>	<p>0%</p>	<p>Үйлдвэрийн барилгын ажлыг</p>	<p>83,685. 5</p>	<p>745.2</p>	<p>ТӨБЗГ – ТӨҮЗХ</p> <p>Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX-EW) технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэр /Катодын зэсийн үйлдвэр/-ийн ТЭЗҮ</p>		

ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.	2020-2022	оруулалт 34% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 66% гадаад/дотоод хөрөнгө оруулалт, зээл/	гүйцэтгэж дуусгана. 100%	<p>болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгийг сонгон шалгаруулах тендерийг 2021 оны 4 дүгээр сард зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүй тул ТБОНӨХБАУХАТ хуулийн 30.4.1 дэх заалтын дагуу 3 удаа зарласны эцэст хураангуй жагсаалт бүрдэж, "Mining short long term" ХХК шалгарсан. Тус компанитай 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр 6/006-21 тоот гэрээ байгуулсан. Гэрээний дагуу санхүүжилтийн 30% буюу 745.2 сая төгрөгийг шилжүүлсэн. Эхний шатны ажлын явцын тайланг 2021 оны 12 дугаар сарын 05-нд хүлээж авсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч компани ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төслийн ажлыг дуусган 2022 оны 8 дугаар сард хүлээлгэж өгнө.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/91 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Эрдэнэтийн овоо эс молибдены ордын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор жилд 10.0 мянган тонн катодын эс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр УУХҮЯ-ны ЭБМЗөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж, дэмжигдсэн.</p> <p>Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX/EW технологитой катодын зэсийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 2023 оны 2 дугаар улиралд эхлүүлнэ.</p>
Хэрэгжилт: 30.0 хувь	Тэмдэглэл: Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX-EW) технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэр /Катодын зэсийн үйлдвэр/-ийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил гэрээний дагуу			

										Гүйцэтгэгч компани 2022 оны 8 дугаар сард хүлээлгэж өгнө Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX/EW технологитой катодын зэсийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 2023 оны 2 дугаар улиралд эхлүүлнэ.
3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.										
3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулал-таар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.	1.Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорац ийг шинээр байгуулна.	БХБЯ, ТӨБЗГ 2020-2024	-	-	Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац ийг шинээр байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	-	-	-	-	ТӨБЗГ – ТӨУЗХ Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний едрийн хуралдаанаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК болон “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийг нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулж төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 13 дугаар тэмдэглэл гаргасан. Уг тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагууд нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Сандагсүрэн болон бусад холбогдох албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулж, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар ярилцсан. “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” ХХК байгуулах асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийг татан буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар шийдвэрлэсэн байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас

								<p>ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэх, зохих шийдвэр гаргах боломжтой юм.</p> <p>Хэрэгжилт: 50.0 хувь.</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор ТӨБЗГазар нь холбогдох судалгааг хийж, Ерөнхий сайд, ЗГХЭГазар, БХБЯамны сайдуудад танилцуулан, зөвшилцөж, улмаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан. Энэхүү шийдвэрийн дагуу ТӨБЗГазраас холбогдох зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн.</p> <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд гаргах шийдвэр хүлээгдэж байна.</p>
--	--	--	--	--	--	--	--	---

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. "Цахим Монгол"- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

4.1.4. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	5. Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2	ТӨБЗГ 2021-2024	1,200.0 Улсын төсөв	Програм-мын болон техник хангамжийг сайжруулах шаардлагатай.	Программ хангамжийг сайжруулах төлөвлөгөө гаргаж, техник хангамжийн төсвийг батлуулан байна.	800.0		<p>ТӨБЗГ – ТӨБАХ, МТА, ЗУХ</p> <p>Шинээр төлөвлөж буй систем нь Монгол Улсын төрөөс хэрэгжүүлж буй "Цахим монгол үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд төрийн өмчийн бүртгэл мэдээллийн удирдлагын тогтолцоо, мэдээлэл солилцоог боловсронгуй болгох замаар төрийн өмчийн үр ашгийг хөрөнгө орууллагуудыг үгүй болгох, нэгдсэн бодлого, удирдлагаар хангахад чиглэгдэж байгаа. Уг системд төр, орон нутгийн өмч бий болох, түүнтэй холбоотой үүсэх бүхий л процесс, байгууллагуудын бүртгэлийг нэгтгэж бүртгэхээр төлөвлөсөн.</p>
--	---	-----------------	------------------------	--	--	-------	--	---

	<p>ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно.</p>								<p>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 1.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн гүйцэтгэхээр батлагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгоход шаардлагатай програм хангамж, техник хангамж, сервер худалдан авах тендерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарлаж, гүйцэтгэгч компаниудыг шалгаруулсан. Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсантай холбоотой Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт орсны дагуу батлагдсан төсөв нь хасагдсан тул гэрээ байгуулах боломжгүй болгоод байна.</p> <p>Хэрэгжилт: 90.0 хувь</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлж, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд 1,200.0 сая төгрөг батлуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгоход шаардлагатай програм хангамж, техник хангамж, сервер худалдан авах тендерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарлаж, гүйцэтгэгч компаниудыг шалгаруулсан.</p>
<p>4.2.Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.</p>	<p>1. Төрийн өмчийн бодлого,</p>	<p>ТӨБЗГ 2021-2024</p>	<p>-</p>	<p>Эрх зүйн орчин сул,</p>	<p>Төрийн болон орон нутгийн</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>ТӨБЗГ – ХЭЗХ, ТӨУЗХ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн</p>	

<p>ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулал- тын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.</p>	<p>зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана.</p>	<p>бүтэц, орон тоо, төсөв хангалт- гүй.</p>	<p>өмчийн асуудлыг хариуцсан тохируулагч агентлаг бий болсон байна.</p>		<p>асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусын асуудлыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудал тусгагдсан бөгөөд "Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг Засгийн газрын тохируулагч агентлаг /цаашид "Төрийн өмчийн хороо" гэж хэрэгжүүлнэ." гэж зааж өгсөн.</p> <p>Түүнчлэн, Төрийн өмчийн хороо нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, орон тооны бус найман гишүүнтэй байна. Засгийн газар нь Төрийн өмчийн хорооны бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, дарга, гишүүнийг томилж, чөлөөлнө. Төрийн өмчийн хорооны хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааны шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна гэх зэрэг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаас гадна хэрэгжүүлэх чиг үүргийг тоочин зааж өгсөн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг ийнхүү тодорхой болгон нарийвчлан зааж хуульчлахаар төсөлд тусгаж байгаа болно.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 46 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалтад "... Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг Төрийн өмчийн корпораци болгож өөрчлөн зохион байгуулах асуудлыг судалж, холбогдох саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах..." гэж заасныг үндэслэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газрын засаглал, ашигт ажиллагаа, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах, өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, өгөөжийг нэмэгдүүлэх, нэгдмэл удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор холбогдох саналыг боловсруулан ЗГХЭГ-т 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А-1/1688</p>
--	---	---	---	--	---

									<p>дугаар албан бичгээр хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Засгийн газрын хуралдаанд 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр хэрэглэгдэж, зарчмын зөрүүтэй асуудлыг цэгцлэх зорилгоор буцаагдсан.</p> <p>Хэрэгжилт: 70.0 хувь</p>
2.Төрийн өмчит болон: төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна.	ТӨБЗГ 2020-2024	196.0	19 хуулийн этгээд	25 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийсэн байна.	60.0	21.1	<p>ТӨБЗГ – ТӨХШХ</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2022 оны эхний хагас жилд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу газрын даргын баталсан удирдамжаар 11 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. "Монголросцветмет" ТӨҮГ; 2. "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ 3. "Багануур АЗЗА" ТӨХК; 4. "Дорноговь АЗЗА" ТӨХК; 5. "Харгуй" ТӨХК; 6. "Архангай АЗЗА" ТӨХК; 7. "Өвөрхангай АЗЗА" ТӨХК; 8. "Хархорин АЗЗА" ТӨХК; 9. "Талын зам" ТӨХК; 10. "Төв АЗЗА" ТӨХК; 11. "Эрдэнэсант АЗЗА" ТӨХК. <p>2022 оны эхний хагас жилийн байдлаар 2 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, шалгалтаар илрүүлсэн 439.64 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг баталгаажуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - "Төв АЗЗА" ТӨХК – 197.6 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 226 дугаар тогтоолоор; - "Өвөрхангай АЗЗА" ТӨХК – 242.04 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 282 дугаар тогтоолоор. 		

								<p>Шалгалтын мөрөөр авах 23 арга хэмжээг дээрх тогтоолуудад тусган тухайн компанид хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байна.</p> <p>Хяналт шалгалтын дүнд гарсан тогтоол, тайланг мэдээллийн нэгдсэн санд оруулж, баяжуулалт хийсэн.</p> <p>2022 оны эхний хагас жилд 11 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын ажлын тайланг боловсруулж байна.</p> <p>Төрийн өмчийн хяналт шалгалтын ажлаар орон нутагт ажиллах томилолтын зардалд 80.3 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулахаар батлагдсан бөгөөд тайланг хугацаанд нийт 21.1 сая төгрөгийн төсөв зарцуулаад байна.</p> <p>Хэрэгжилт: 70.0 хувь</p> <p>Тэмдэглэл: 2022 оны эхний хагас жилд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу газрын даргын баталсан удирдамжаар 11 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалт хэрэгжүүлсэн.</p>
<p>3.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ.</p>	<p>ТӨБЗГ 2020-2024</p>	<p>75.0</p>	<p>7 хуулийн этгээд</p>	<p>10 төсөвт байгууллагад шалгалт хийсэн байна.</p>	<p>20.0</p>	<p>0</p>	<p>ТӨБЗГ – ТӨХШХ</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 22-02/01 дүгээр шалгалтын удирдамжийн дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа дараах 10 салбар нэгжид системийн хяналт шалгалтыг эхлүүлсэн. Тус шалгалт нь 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал үргэлжилнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Улаанбаатар хотын Гаалийн газар; 2. Замын-Үүд дэх Гаалийн газар; 3. Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар; 4. Өмнөговь аймаг дахь Гашуун сухайт Гаалийн газар; 5. Өмнөговь аймаг дахь Шивээ хүрэн дэх Гаалийн газар; 	

								<p>6. Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газар; 7. Ховд аймаг дахь Гаалийн газар; 8. Дорноговь аймаг дахь Сайншанд Гаалийн газар; 9. Увс аймаг дахь Гаалийн газар; 10. Сүхбаатар аймаг дахь Бичигт Гаалийн газар зэрэг болно.</p> <p>Гаалийн ерөнхий газрын харьяа 10 салбар нэгжид 2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалт, их засварын мэдээллийг цуглуулан, боловсруулалт хийж байна.</p> <p>2021 онд он дамжин 2 хуулийн этгээдэд системийн хяналт шалгалт гүйцэтгэн, хяналт шалгалтын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, илрүүлсэн 245.94 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг баталгаажуулсан шийдвэр гаргасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Халдварт өвчин судлалын үндэсний төв – 19.02 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 224 дүгээр тогтоолоор; - Хавдар судлалын үндэсний төв – 226.93 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 225 дугаар тогтоолоор. <p>Шалгалтын мөрөөр авах 16 арга хэмжээг дээрх тогтоолд тусгаж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байна. Хяналт шалгалтын дүнгээр гарсан тогтоол, тайланг мэдээллийн нэгдсэн санд оруулж, баяжуулалт хийсэн.</p> <p>Хэрэгжилт: 70.0 хувь</p> <p>Тэмдэглэл: Гаалийн ерөнхий газрын харьяа 10 салбар нэгжид 2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалт, их засварын мэдээллийг цуглуулан, боловсруулалт хийж байна.</p>
--	--	--	--	--	--	--	--	---

4.4. Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.						
4.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.	1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.	ХЗДХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч) 2020-2023	20.0	Хуулийн төслийг боловсруулсан байна. 740.0/	Хуулийн төслийг батлуулсан байна.	-
						<p>ТӨБЗГ – ХЭЗХ</p> <p>ТӨБЗГ-ын 2021 оны А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, судалгааг шинэчлэн холбогдох баримт материалын хамт хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн.</p> <p>2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр ХЗДХЯ-нд уг хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг 2022 оны эхний хагас жилд 5 удаа хуралдаж, хэлэлцүүлгээс гаргасан болон яамд, аймаг, орон нутгаас ирүүлсэн саналыг төсөлд тусган Засгийн газрын 05 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд танилцуулав. Хуралдаанаас хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал гарсан тул дэмжихээс татгалзаж хойшлуулсан.</p> <p>Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг ХЗДХЯ-аас боловсруулж, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд УИХ-д өргөн барихыг дэмжсэн. Уг хуулийн төслийг 05 дугаар сарын 04-ний өдөр УИХ-д өргөн барьсан бөгөөд Эдийн засгийн Байнгын хорооны хуралдаанаас УИХ-аар хэлэлцүүлэхээр дэмжсэн. УИХ-ын 06 дугаар сарын 09-10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэх тухай асуудлыг</p>

								<p>хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Хэрэгжилт: 70.0 хувь</p> <p>Тэмдэглэл: Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг ХЗДХЯ-аас боловсруулж, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихыг дэмжсэн. Уг хуулийн төслийг 05 дугаар сарын 04-ний өдөр УИХ-д өргөн барьсан бөгөөд Эдийн засгийн Байнгын хорооны хуралдаанаас УИХ-аар хэлэлцүүлэхээр дэмжсэн. УИХ-ын 06 дугаар сарын 09-10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн.</p>
<p>2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална.</p>	<p>ТӨБЗГ 2021-2023</p>	<p>-</p>	<p>Зарим дүрэм, журам батлах эрх хуулиар олгогдоогүй.</p>	<p>Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын асуудлаар 3 журмын төслийг баталж, мөрдүүлсэн байна.</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>ТӨБЗГ – ХЭЗХ</p> <p>Хуулийн төсөл одоогоор батлагдаагүй ч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой дагалдан гарах дүрэм, журмын хүрээнд тайлант хугацаанд, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам", гэрээний загварыг баталж мөрдүүлээд байна.</p> <p>Хэрэгжилт: 50.0 хувь</p> <p>Тэмдэглэл: "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий</p>	

	3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ.	ТӨБЗГ 2021-2024	-	Компанийн засаглалын дундаж үнэлгээ - 53.9 хувь	Компанийн засаглалын олон улсын сайн туршлагыг нэвтрүүлсэн байна.	-	-	<p>хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”, гэрээний загварыг баталж мөрдүүлээд байна.</p> <p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Олон Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (OECD)-аас баталсан “Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалын зарчим”-г баримтлан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг төрийн албаны мерит зарчимд тулгуурлан томилон ажиллуулахаар нэр дэвшүүлэх, сонгох нь компанийн засаглал сайжрах, төлөөлөн удирдах зөвлөл мэргэжлийн, чадварлаг болгох, төрийн хувьцааг олж авах, захиран зарцуулах, хувьцаанд ногдох эрхийг хэрэгжүүлэх механизмыг зөв тогтоох, энэ агуулгаар төр хувьцааг тооцоо, судалгааны үндсэн дээр тодорхой салбарт эзэмших, хувьцаа эзэмшигчийн ямар эрхээ аль байгууллагаар дамжуулж хэрэгжүүлэх хуваарилалт, хариуцлагын эргэх холбоо, тайлагнал, ил тод байдлыг хангах зарчмуудыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тусгасан болно.</p> <p>Уг хуулийн төслийг УИХ-ийн ЭЗБХ болон УИХ-ын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн бөгөөд анхан шатны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэр гаргасан.</p> <p>Компанийн засаглалын олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх хүрээнд Төрийн өмчит болон төрийн оролцоотой 106 аж ахуйн нэгжийн 2021 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн үр дүнг тооцохдоо олон улсын байгууллагууд компанийн ерөнхий үзүүлэлтийг тодорхойлохдоо баримталдаг зарчим болох хөрөнгийн өгөөж, эдийн өмчийн өгөөжийн үзүүлэлтийг тооцон гаргасан. Цаашид төрийн өмчит хуулийн этгээдүүдэд энэ туршлагыг нэвтрүүлэх бөгөөд</p>
--	---	--------------------	---	---	---	---	---	---

ТӨБЗГ-аас баталсан холбогдох журмын шалгуур үзүүлэлтэд хөрөнгө өгөөжийг сайжруулсан байдал, эздийн өмчийн зохистой харьцааг харгалзах үзүүлэлтүүдийг тусгаж өгсөн болно.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, "Компанийн Засаглалын хөгжлийн төв" ТББ-тай хамтран ажиллаж, "Монгол шуудан" ХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Амгалан дулааны станц" ТӨХК, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК, "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК, "Дулааны хоёрдугаар цахилгаан станц" ТӨХК гэсэн төрийн өмчит 9 компанийн засаглалын үнэлгээг хийлгэсэн. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 2021 онд 64.8 хувь байсан бол 69.0 хувьд хүрсэн байна.

Хэрэгжилт: 70.0 хувь

Тэмдэглэл: Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл боловсруулагдаж, УИХ-ийн ЭЗБХ болон УИХ-ын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн бөгөөд анхан шатны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэр гаргасан. Компанийн засаглалын олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх хүрээнд Төрийн өмчит болон төрийн оролцоотой 106 аж ахуйн нэгжийн 2021 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн үр дүнг тооцохдоо олон улсын байгууллагууд компанийн ерөнхий үзүүлэлтийг тодорхойлохдоо баримталдаг зарчим болох хөрөнгийн өгөөж, эздийн өмчийн өгөөжийн үзүүлэлтийг тооцон гаргасан. Цаашид төрийн өмчит хуулийн этгээдүүдэд энэ туршлагыг


	<p>4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	ТӨБЗГ 2022-2024	-	Хуулийн этгээдэд урт болон дунд хугацааны бизнес /хөгжлийн/ төлөвлөгөө байхгүй.	Хуулийн этгээдийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө баталсан байна.	-	-	<p>нэвтрүүлэх бөгөөд ТӨБЗГ-аас баталсан холбогдох журмын шалгуур үзүүлэлтэд хөрөнгө өгөөжийг сайжруулсан байдал, эздийн өмчийн зохистой харьцааг харгалзах үзүүлэлтүүдийг тусгаж өгсөн. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 69.0 хувьд хүрсэн.</p>
	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Төрийн өмчит хуулийн этгээдийн зорилтын санал, тухай жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн тухай хуулийн этгээдийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгчид болон компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан мөрдлөг болгон ажиллаж байгаа болно.</p> <p>/"Эрдэнэт үйлдвэр" ТӨУГазар 2021 он хүртэл, "Монголросцветмет" ТӨУГазар 2024 онд хүртэл, "Эрдэнэс монгол" ХХК, "Эрдэнэс таван толгой" ХКомпани 2025 он хүртэл гэх мэт/ Төрийн өмчит бусад хуулийн этгээдүүд 1-4 жилийн бизнес төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь 2021 оны жилийн эцсийн байдлаар 53,482.0 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 10,649.0 тэрбум төгрөгийн орлого олж, 1,035.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого 8.7 хувиар буюу 860.0 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 407 тэрбум буюу 831.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 2020 оны цэвэр ашгаас 2021 онд төрийн өмчийн ногдол ашигт 209.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бол 2022 онд Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар</p>							

<p>хүлээсэн үүргийн дагуу 45.5 тэрбум төгрөгийг ногдол ашгаар, ирээдүй өв санд 535.1 тэрбум төгрөгийн хувьцааны ногдол ашиг төвлөрүүлэх төвлөлөгөөтэй бөгөөд хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд ТӨБЗГ-ын хуралдаанаар Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны Улсын төсөв болон ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай асуудлыг боловсруулан хэлэлцүүлэн шийдвэрлүүлэн хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит үйлдвэрийн газруудын захирал болон төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А-1/947 дугаар албан бичгээр төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийг чөлөөлж, цалин хөлсний зардлыг хэмнэх, чөлөөлөгдсөн удирдах ажилтнуудад ижил эрх үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгохгүйгээр хуулийн этгээдийн зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлох, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэх, хэмнэлтийн горимд ажиллах, үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, нийтийн арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, 2021 оны санхүүгийн тайлан тэнцэлд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, өглөг, авлагыг бууруулах арга хэмжээг авч ажиллах зэрэг чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аваад байна.</p>								
--	--	--	--	--	--	--	--	--

									<p>Хэрэгжилт: 90.0 хувь</p> <p>Тэмдэглэл: Төрийн өмчит хуулийн этгээдийн зорилтын санал, тухай жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн тухай хуулийн этгээдийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгчид болон компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан.</p>
<p>5. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.</p>	<p>ТӨБЗГ 2021-2024</p>	<p>425.0 Улсын төсөв</p>	<p>2016 оны улсын нэгдсэн тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн.</p>	<p>900 хуулийн этгээдтэй байгуулсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн байна.</p>	<p>25.0</p>	<p>141.0</p>	<p>ТӨБЗГ – ТӨБАХ</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний 4.4.1-д төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийх, хяналт тавих тухай асуудал тусгагдсан бөгөөд шаардлагатай нийт 301.0 сая төгрөгийн төсөв 2022 оны улсын төсөвт тусгагдан батлагдсан болно. Тайлант хугацааны гүйцэтгэлээр тооллогын мэдээллийн системийн техник хангамжийн асуудлыг холбогдох хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар худалдан авсан бөгөөд сургалтын зардал орсон дүнгээр нийт 141.0 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолд нийцүүлэн ТӨБЗГ-ын 2022 оны 64 дүгээр тогтоолоор улсын үзлэг, тооллогын ажлыг удирдан зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүн, журам, маягт, заавар, арга зүйг баталсан.</p> <p>Тооллогын ажлын журам, заавар, маягт холбогдох бусад баримтыг нэгтгэн гарын авлага боловсруулж, 6300 хувь хэвлүүлэн ТӨБЗГ, нийслэл Өмчийн харилцааны газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газраар дамжуулан үзлэг</p>		

								<p>тооллогод хамрагдах бүх байгууллагад хүргүүлсэн.</p> <p>ТӨБЗГ-ын даргын 2022 оны Б/20 дугаар тушаалаар нийслэл, 21 аймагт холбогдох арга зүйн сургалт, семинарыг газар дээр нь болон цахимаар 3 удаа зохион байгуулж, удирдамжаар ханган ажилласан.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг эхлүүлсэн.</p> <p>Аstvision ХХК-тай хамтарч улсын үзлэг, тооллого, өмчийн бүртгэлийн програм хангамжийг хөгжүүлж, туршин ашиглаж байна. www.buigtel.prcsp.gov.mn веб хуудсыг тооллогын програмтай холбож, сургалтад ашигласан бөгөөд шаардлагатай асуудлаар нэмэлт зөвлөмж, мэдээлэл байршуулан toologo@prcsp.gov.mn цахим шуудангаар холбогдох санал хүсэлт, гомдол, асуулт зэргийг хүлээн авч, хариулт өгч байна.</p> <p>Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Төв аймаг дахь болон нийслэл байгаа төрийн өмчит нийт 400 хуулийн этгээдийн “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнээд байна, үлдсэн байгууллагын гэрээг дүгнэх ажил үргэлжилж байна. Гэрээний дүнг нэгтгэн 3 дугаар улиралд Газрын хуралдаанд танилцуулахаар төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.</p> <p><u>Хэрэгжилт: 70.0 хувь</u></p> <p><u>Тэмдэглэл: 2022 оны улсын төсөвт төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажил зохион байгуулахад шаардагдах 301.0 сая төгрөг батлагдаж, тайлант хугацаанд гүйцэтгэлээр 141.0 сая төгрөгийг зарцуулсан. Нийслэл болон 9 аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг хийж</u></p>
--	--	--	--	--	--	--	--	---

												байгаа бөгөөд төрийн өмчит 400 хуулийн эгтээдийн "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын дүн IY улиралд, гэрээний дүн III улиралд нэгтгэгдэн танилцуулагдана.
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---



Танилцсан:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ТАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:
**ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН**

Д.ЦЭРЭНЛХАМ